


Захирлын зөвлөлийн 2014 оны 2 дугаар сарын 21 өдрийн хурлаар батлав.



СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ ТӨҮГ-ЫН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг :Ерөнхий зүйл:

1.1. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” ТӨҮГ-ыг Төрийн өмчийн хорооноос Эрчим хүчний яамтай зөвшилцөн томилогдсон Захирал удирдана. Захирал нь Төрийн өмчийн хороотой үр дүнгийн /контрактын/ гэрээ байгуулж ажиллана.

1.2. Захиралд зөвлөх эрх, үүрэг бүхий захирлын зөвлөл ажиллах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг захирлын тушаалаар тогтооно.

1.3. Захирлын зөвлөлийн зорилго нь тус ТӨҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааны өмнө тулгамдсан асуудлыг шуурхай шийлдэрлэж, цаашдын хөгжил, чиг хандлагыг тодорхойлоход оршино.

Хоёр:Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн.

2.1. Захирлын зөвлөл нь захирлын зөвлөлийн дарга, гишүүдээс бүрдэнэ. Захирлын зөвлөлийн дарга нь Захирал байна.

2.2. Захирлын зөвлөл нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- Дэд захирал /Ерөнхий инженер/
- Хэлтсийн дарга нар
- Ерөнхий нягтлан бодогч
- Хүний нөөц, хууль эрх зүйн мэргэжилтэн орно.

2.3. Захирлын зөвлөлд хамт олны төлөөлөл болгон ҮЭХ-ны даргыг оруулж болно.

Гурав:Гүйцэтгэх чиг үүрэг.

3.1. Байгууллагын хэтийн болон ойрын зорилтыг тодорхойлж холбогдох дээд байгууллагуудаар батлуулж мөрдөх.